



ИРГЭНИЙ НИСЭХИЙН  
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2023 оны 03 сарын 10 өдөр

Дугаар А/38

Улаанбаатар хот

Бараа хүлээн авах комисс томилох тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Иргэний хуулийн 243 дугаар зүйлийн 243.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.6 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "ЧХОУНБШХА-ны диспенсер, сумлагч автомашины шүүр элемент нийлүүлэх" ИНЕГ/УЗ/80/2022 дугаартай гэрээний дагуу нийлүүлэх бараа хүлээн авах комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр томилсугай. Үүнд:

Комиссын дарга:

Б.Гантулга

(Иргэний нисэхийн үндэсний төвийн Газрын тусгай  
үйлчилгээ, шатахуун хангалтын албаны ерөнхий  
инженер)

Гишүүд:

Ц.Уянга

(Иргэний нисэхийн үндэсний төвийн Нисэх  
буудлуудын үйлчилгээний газрын газрын  
үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн)

У.Амгалан

(“Чингис хаан” олон улсын нисэх буудал дахь  
Шатахуун хангалтын албаны чанарын менежер)

Г.Ган-Эрдэнэ

(“Чингис хаан” олон улсын нисэх буудал дахь  
Шатахуун хангалтын албаны төлөвлөлтийн  
мэргэжилтэн)

17120 0205

Нарийн бичгийн  
дарга:

Н.Отгонжаргал  
(Иргэний нисэхийн үндэсний төвийн Хөрөнгө  
оруулалт, захиалагчийн албаны Төлөвлөлт,  
гүйцэтгэлийн тасгийн инженер)

2.Гэрээний тусгай нөхцөл, техникийн тодорхойлолт, холбогдох баримт бичиг, стандартад дурдсан шаардлагуудын дагуу шалган хүлээн авах, санхүүгийн бүртгэлд тусгуулах, комиссын акт, холбогдох бусад материалыг бүрдүүлж, 2023 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн дотор Хөрөнгө оруулалт, захиалагчийн албанд хүргүүлэхийг Бараа хүлээн авах комисс (Б.Гантулга)-т, гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, удирдлагын газар (Т.Батжаргал)-т тус тус үүрэг болгосугай.

ДАРГА



Ч.МӨНХТУЯА